

УГСААТАНЫ СУДЛАЛ

МОНГОЛ ГЭСЭРИЙН ТУУЖ БА БӨӨГИЙН ШАШНЫ УЧИР

Д.ЭРДЭНЭБИЛЭГ

Монгол “Гэсэрийн тууж”-д бөөгийн шашны ул мөр нилээд харагдаж монгол Гэсэрийн үндэсний шинж онцлогийг харуулж байдаг. Ураг төрлийн нийгэмд үйлдвэрлэлийн хүчин туйлын дорой буурай ба эрдэм мэдлэгийн мөчид цулгуйгаас болж эртний монголчууд байгалийн элдэв зүйлийн үзэгдлийг зөвөөр таниж шинжлэх ухаанаар тайлбарлаж чадахгүй, зөвхөн өөрийн ойлголтоор байгалийг эзэн сахиустай хэмээн тайлбарлаж, түүнд халдаж болзошгүй гэсэн сүсэг бишрэлийн улмаас өөрийн хувь заяа, хүсэл эрмэлзлээ тэнгэр буюу эзэн сахиусанд даатгадаг байдал “Гэсэрийн тууж”-д туссан байна. Энэхүү бөөгийн шашны үзэл санаа нь тэнгэрийг шүтэх, сүнсийг шүтэх, төлөг үзэх, зүүд манах, галыг шүтэх зэрэг үзэгдэл алхам дараатайгаар буй болж ардын аман үлгэрийн дотор зураг мэт шингэж өнөө үетэй нүүр золгожээ.

Бөөгийн шашны хамгийн гол шүтээн нь тэнгэр мөн. Бөө мөргөлийн үзэлтийг үндэслэвэл тэнгэр бол амьлалын үндэс бөгөөд арга ухааны эх булаг. Байгаль дэлхийн аливаа хэрэг бодис цөм тэнгэрт захирагдана гэж үздэг тул “Гэсэр тууж”-ийн дотор Гурван бодг тэнгэр, Өргөн цагаан тэнгэр, Дээд хурмаст тэнгэр, Амьд гурван тэнгэр, Хилэнгийн цагаан тэнгэр, Өргийн шар тэнгэр, Гал тэнгэр, Эрхэт тэнгэр, Хар тэнгэр, Гэрч цагаан тэнгэр, Хан мөнх тэнгэр¹ гэх мэтээр илрөч байна. “Авай Гэсэр Хөвүүн” дотор илрэн гарч байгаа тэнгэр гэвэл Аай улаан тэнгэр, Цэгэн цэвтэн тэнгэр, Оёдол цагаан тэнгэр, Оюу гар цагаан тэнгэр, Тавин таван тэнгэр, Есөн дүүлэм тэнгэр, Түмэн цагаан тэнгэрчүүл, Наран дулаан тэнгэр, Олон баян тэнгэр, Бүслүүр цагаан тэнгэр, Бутархай цагаан тэнгэр, Заяан цагаан тэнгэр, Хуртай гурван тэнгэр, Өндөр дүүлэм тэнгэр, Шудургуу цагаан тэнгэр, Буудлын гурван тэнгэр, Цайр цагаан тэнгэр, Улаан цолмон тэнгэр, Хайр хар тэнгэр, Хайр балай тэнгэр, Бүслүүр хар тэнгэр, Бүрт хар тэнгэр, Есөн гурван тэнгэр, Амаржин гурван тэнгэр, Гурван салхин тэнгэр, Бор цоохор тэнгэр, Шар цоохор тэнгэр² гэх мэт олон арван тэнгэр байдаг.

“Буриад гэсэр”³-т Салхин гурван тэнгэр, Гурван жибэр тэнгэр, Гурван эмгэрчин тэнгэр, Зүүн тэнгэр, Баруун тэнгэр, Дөчин дөрвөн тэнгэр, Шар гэрэл тэнгэр, Гурван манан тэнгэр, Гурван унин тэнгэр, Гурван бүрэн тэнгэр гэх мэт олон янзын тэнгэр илрэн гарч байгаа явдал нь тэр чигээрээ бөөгийн шашны илрэл мөн. Иймээс “Гэсэрийн тууж”-ийг балар эртний бөөгийн шашны нөлөө тусгалыг шууд хүртсэн зохиол гэж үзэлтэй. “Гэсэрийн тууж”-д Гэсэр ба түүний баатрууд нь үргэлж дээд тэнгэрийн хүчин дэмжлэгээр аюулт дайснаа дарж дархан цолоо олж буй үйл явдал олонтоо харагдаж байдаг билээ. Жишээлбэл “Ойрад Гэсэрийн тууж”-ийн⁴ 4-р бүлгийн “Гэсэр хааны сарлагийн гурван хаантай дайлалдсан нь” гэх хэсэгт Гэсэр хаан нь байдаг баатруудаа дайсанд алуулсаны дараа дээд тэнгэрийн хүчээр амь оруулж авснаа “Би өдий төдий жил баатруудаа хаяж бүхнийг алуулав. Одоо дээд эцэг

¹ Ю.Чимэддорж харгуулан эмхэтгэсэн “Гэсэрийн тууж”. ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1985

² “Авай Гэсэр хөвүүн”, ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1982

³ Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн утга зохиол судлах газрын “Гэсэр”-ийн албан гэрээс найруулсан “Буриад Гэсэр” 1-р эмхэтгэл

⁴ Анчинхүү. Сэнчинмөнхийн эмхэтгэсэн “Ойрад Гэсэрийн тууж” ӨМ-ын соёлолын хэвлэлийн хороо., 1984

хурмастын сайнаар тэднийг дахин амьдрууллаа" гэж алдаа буруу, эмгэнэл гашуудлаа тоочиж дээд тэнгэрийг сүсэглэн биширснээр барахгүй туужийн үйл явдлыг ихээхэн шидчилсэн байна. Мөн энэ туужид нусгай Жор, Урангоо хүүхнийг хатнаа хийж авахын төлөө Сайнхул хааны хүүхэн Урангоогийн мүрийг авч Сайнхул хаанаа мүрийг нь бас шүүгээд хүүхнийг нь авах зангилгын үед хар санаат Цотон ноён хүрч ирээд дахин хоёр маргаан тавихаар тогтов. Энэ үед Жор дээд тэнгэр сан тавьж "За хайрхаан! Асар хурмаст тэнгэр эцэг Навс гүрж эжий минь ачтан Зас ах минь ялгуусан гурван эгч минь, хамаг маргааныг би аваад Урангоо хүүхнийг авах гэсэн минь бүтээд ирэхлээр хар санаатай Цотон хаан хүүхнийг надад өгөхгүй, бас дахиад хоёр маргаан болохоор тогтов. Энэ хоёр маргааныг чадна уу үгүй юу? та нар мэднэ. Та нараас ондоо надад түшиг болох хүнгүй болов"⁵ гэж наминчлан даатгаж дээд тэнгэрийн дэмжлэгийг хүсэв.

Үүнээс үзвэл Гэсэр хаан бөөгийн шашны төлөөлөгч "Тэнгэр"-ийг ихээр шүтэж байснаар барахгүй хүчир зовлон тулгарах буюу өмөг түшиггүй гачигдах үед удамшилт шүтлэг, бөөгийн шашиndaа даатгаж түүнээс хавсарлага дэмжлэгийг хүсдэг байна. Энэ нь даруй бөөгийн шашин нь нийгэмд зохих байр суурийг эзэлж хүмүүсийн оюун санаанд нөлөөлж итгэл бишрэл болсон цаг үеийн бодит тусгал мөн. Иймэрхүү цаг үеийн тусгал учраас Гэсэр ба түүний баатрууд нь хүчир зовлон тохиолдох үед бүр дээд тэнгэрийн хавсарлага дэмжлэгийг олохоор чармайдаг. Одоо ч гэсэн монгол хүн "Хөх тэнгэр эцэг, Хөрст дэлхий эх" гэж үздэг заншилтай, энэ бол бөөгийн шашны үндсэн үзэл болно.

Монголчууд эрт дээр үеэсээ аливаа хэрэг явдлын сайн, мууг тэнгэрийн зүйгээр үзэж хэрэг учир бүтэж биелэгдэхийг тэнгэрийн ивээлд даатгадаг. Үүгээр үл барам хаан эзэн, баатар хүчтэнийг тэнгэрээс заяатай хэмээх буюу тэнгэртэй холбоыг их л хичээдэг байжээ. Бодитоор хэлбэл "Мэргэд гарахын орон" гэдэг номонд "Их монголын оронд урьд тэнгэрийн хөвүүн, Бөртэ чоно хэмээн алдаршсанаас есдүгээр үеийн Дов мэргэн нөхцөний хойно гэргий нь Алангуга хэмээх бэлэвсэнг байсанд огторгуйгаас солонгын гэрэл мэт нэгэн юм ирж биеэнд туссанаас амгалан амсаж жирэмсэн болоод нярайлсан хөвүүнийг Бодончир хэмээн нээрлэвээ" гэсэн бөгөөд XIII зууны үеийн утга зохиолын үнэт дурсгал "Монголын Нууц Товчоо"-нд "Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат Бөртэ чоно ажгуу, гэргий нь Гуа марал ажгуу"⁶ гэж тэмдэглэсэн байхад "Гэсэрийн тууж"-д Гэсэрийг "Эрхт тэнгэрийн хөвүүн нь эзэн Гэсэр хаанаа өшөөт мангасыг алсан буйяа"⁷ гэжээ. Нанчин баатар өөрийн биеэ "Би тэнгэрийн хөвүүн арван таван наст эрдэнэт Нанчин би бишүү" гэж "Тэнгэр заяат"-аар мэдүүлсэн байна. Иймэрхүү тэнгэр заяат учраас тэдгээр баатрууд хандсан зүйтээ дайсангүй аливаа бүхнийг бүр өвдөг дороо дарах үзэл нь чив хэмээн бөөгийн шашны нөлөө мөн.

Эртний үед энэхүү "тэнгэр"-т "сайн муу", "дээр дорд" ялгаа байдаггүй. Зөвхөн агаар огторгуй дээр оршиж байгаль нийгмийг ямар нэгэн далдын хүчээр захирч байхаар үздэг. Нөгөө талаар эртний нүүдэлчин малчид тэнгэр дуугарч, цахилгаан цахилан хайрга буух, бороо орж усан гамшиг болох, салхи шуурга дэгдэн цагаан зуд болж мал сүрэг жич хүн амьтанд туйлын их аюул зовлонг авчирахад тэд нар энэ бүхэн нь бүр тэнгэр хилэгнэн уурласнаас боллоо гэж үзээд тэнгэрийг үхэн шүтэж, бишрэн тахидаг байна. Сүүлээр нийгмийн аж ахуйн хөгжилд хүний үзэл ухамсарын дээшлэлтийг дагалдан энэхүү "тэнгэр" ч ангид чанартай болсноос "сайн муу тэнгэр",

⁵ Мөн тэнд

⁶ Манисангийн шинээр орчуулж тайлбарласан "Монголын нууц товчоо" ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1985

⁷ Ю.Чимэддорж харгуулан эмхэтгэсэн "Гэсэрийн тууж". ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1985

"зүүн баруун тэнгэр", "хар цагаан тэнгэр"-ийн ялгаа гарч бөө мөргөлд чанарын хувиралт гарсан болохоор "бөө мөргөл нь байгаль өртөнцийн үзэгдэл бүхнийг нэг тэнгэрт захируулдаг байна"⁸. Түүхэн бичигт "Татаар үндэстэн цөм нэг эзэн байхыг зөвшөөрч тэнгэртэй хамтатган тэнгэр хэмээдэг"⁹, "Татарчуудын бишрэл сүсэг ... нэгэлхэн эзэн мэдэгчтэй байхыг бүгдээр зөвшөөрч тэнгэр лугаа хослуулж тэнгэр хэмээвээ"¹⁰ үүнээс үзвэл ноёрхогч анги өөрийн төрөө улам сайн бэхжүүлэхийн төлөө "тэнгэр"-ийг их шүтэж өөрийн биеэ тэнгэрээс заяатай хэмээх онолыг дурьдан гаргаж олны хүндэтгэлийг олж хувийн зорилгоо биелүүлж байсан байна.

Төлөг үзэх явдал бол бөөгийн шашны нэг зүйлийн ёслол байж монголын нийгэмд өргөн тархан дэлгэрсэнээс "Гэсэрийн тууж"-д нөлөө тусгалаа олж идээшэн боловсорсон байна.

"Гэсэрийн тууж"-д төлөг үзэж алс ирээдүйгээ бусдын нууц далд учир явдлыг мэдэхээр илэрсэн зүйл арвин гарч байдаг. Тухайлбал Цотон ноён бэрдээ атаархаад мангаст хараал хийсэнд мангасын толгой өвдсөнөө мангас толгой минь юунд өвдөв үү? гэж төлөгний улаан утсаа авч үзсэнд арван зүгийн эзэн Гэсэр хааны өөр өмчид өөр нутагтай өнгө гэрэл үзэсгэлэнт сайхан Гуа хатан байхыг мэдсэн бөгөөд хараалын нүхнээс олон муу үг асууж ирээд гурван намнаганд миний юм хийж надад муу сэтгэж асгасан байна. Тэр шалтгаанаар миний толгой өвдөв гэж төлөг үзжээ¹¹. Иймэрхүү төлөг үзэж хожим ирээдүй, алс холын хэрэг явдлыг урьдчилан мэдэх үзэгдэл нь тэр чигээрээ бөө мөргөлийн нэг агуулга нь болно.

Монголчууд эрт дээдийн үеэс төлөг үзэж мэргэлдэг заншилтай юм. Чингис хаан цэрэг дайнд мордохоосоо өмнө төлөгчнөөр хонины далыг шатаалгаж сайн муу ёрын төлгийг үзүүлж учир явдлыг цагаатган шийдвэрлэсний дараа сая цэрэг хөдөлгөдөг байна. Сурвалж бичигт "тэд төлөг үзэхдээ хонины дал ясыг шатааж гарсан зурхайны сөрөх ба зэрэхийг үзэж сайн, муу ёрыг ялгадаг. Тэнгэрийн ивээх эсэхийг үүгээр тогтооно. Үүнийг хэцүү гэж папа /дал/ шатаана гэнэ. Хүнд, хөнгөн явдал гэж ялгалгүйгээр эрх биш төлгөддөг"¹² гэж тодорхой тэмдэглэж байна.

Плано Карпини, Вильям Рубрукын "Монголд зуучилсан тэмдэглэл"-д "нэг удаа Мөнх хааны хатанд маш үнэт ангийн үсээр бэлэг иржээ. Хатан түүнийг төлөгч бөө нарын ариун галаар ариутгаж ордонд оруулахыг тушаажээ. Төлөгч бөө нар уул зүйлийг галаар ариутгаж үлдээж авах ёстой хувиа аваад хатанд хүргүүлжээ. Гэтэл нэг эмэгтэй төлөгч бөө нар авах хувиас илүү их авч байхыг үзээд учрыг хатанд айлтгажээ. Хатан уурлаж төлөгч бөө нарыг дуудаж зэмлэжээ. Дараагаар нь удсангуй хатан хүнд өвчилсөн юм. Төлөгч бөө нараар бөөлүүлэхэд харь орны бузар муу эмэгтэй хүнээс болсон гэж төлгөджээ Мөнх хааны анхдугаар хатнаас нэг хүү төрж гэнэ. Төлөгч нарыг авч ирээд хүүгийн хувь заяаг мэргэлүүлсэнд төлөгч бөө нар хаан хүүг урт наслаж удаан жаргана, төрийг эзэлсэн том хаан болж улс гүрэн улам цэцэглэн мандах болно"¹³ гэж төлөгджээ.

Өгөөдэй хаан Алтан улсад мордож "Тэнд Өгөөдэй хаан гэнэт өвчинд нэрвэгдэж уг хэлж чадахгүй болов. Бөө буулгаж төлөг татуулан үзүүлсэнд Хятад улсын газар үсны эзэн сахиулсан ард иргэнээ автагдаж хот балгасаа эвдсэнд ад үзэж хорлов"¹⁴ усны эзэн сахиулсан ард иргэнээ автагдаж хот балгасаа эвдсэнд ад үзэж хорлов" гэж төлгөдсөн адилаар "Гэсэрийн тууж"-д Мое гүүш /Данбу/ төлөгч уулсын хаан Мова гүнжид энэ гурван төлөгчинд Арьяя Алмахир охин цагаан тэнгэрээс тэр гурван

⁸ Ч.Далай. "Монголын бөө мөргөлийн товч түүх".

⁹ Доссон. "Монголын түүх". ӨМӨЗО.

¹⁰ Пундай яа. "Хар татаарын тухай хэргийн товч". ӨВӨЗО. 1956

¹¹ Ю.Чимэддорж харгуулан эмхэтгэсэн "Гэсэрийн тууж". ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1985

¹² Пундай яа. "Хар татаарын тухай хэргийн товч". ӨВӨЗО. 1956

¹³ Плано Карпини, Вильям Рубрук. "Монголд зуучилсан тэмдэглэл" /Гэрэлцогтын орчуулсан/. ӨМ., 1983

¹⁴ "Алтан түлхүүр" сэтгүүл. 1985. №5

төлгөчид энэ өртөнцийн самууныг дарангуйлан чадах хаан төрөх үү? үгүй юу? төлөг орхиж үз гэв. Түүнд Мөо Гүүш төлөгч төлгөө орхиод Бова Дүргүб карб нэртэй молор эрдэнэ биетэй, дун цагаан шүдтэй, гарьд шувуун толгойтой, алтан шар хонхорцог үстэй үзүүр нь уд модонд цэцэг дэлгэрсэн мэт хөвгүүн төрөх юмаа. Тэр төрвөл дээд тэнгэрийг эзлэгч мөн гэж төлөгдсөн бөгөөд төлөгч нар Гэсэрийн эцэг эх нь хэн болох, ямар газар байхыг бүр төлгөдөж мэдсэн байна. Иймэрхүү бөөгийн шашны үүднээс бэлэг ёр заадаг төлөгч ба бөө нараар төлөг үзүүлж ирээдүйн юмыг урьдчилан мэдэх үзэгдэл “Гэсэрийн тууж”-д олонтоо илэрч байгаа явдлаас туужийн төлөвшөн цаг үеийг ихэвчлэн барагцаалахад олдошгүй зүйл болно.

Монгол хүн галыг хамгийн ариун цэврээр үзэж бузар юмыг галаар ариутган цэвэрших заншил нь бөөгийн шашны чухал нэг агуулга нь болно. Бид “Гэсэрийн тууж”-ийг ашиглаж үзвэл тус туужид хортой дайсан мангасыг галаар түймэрдэж алах үйл явдал арвин гардаг юм. Юунд гэвэл гал хүн төрөлхтөнд дулаан бүлээнийг авчирч, амьдралын нөхцлийг нь сайжруулж, өөдлөн дээшлэхийн бэлэг тэмдэг, ариун цагаан онгон сүнс мөн гэж үздэг тул бузар буртаг, муу муухай зүйлийг галаар ариутгаж түлдэг байна. “Авай Гэсэр хөвүүн”-д Ширэм хар Минаат хааныг алсны дараа авай Гэсэр хөвүүн Эрчин Шуумир баатартайгаа: “дарагдашгүй дайснаа дарав бид, давагдашгүй даваагаа давав бид” гэж ой мод огтолж орвогтой залаатай нь цуглуулж тайгын модыг тайрч, хууртайтой нойтонтой нь татуулав. Үхлийн наад бие дэх жаргалын цаад бие дэх Ширмэн хар Минаат, ширүүн хар Анахайг галдаж шатааж газар тайдаа ариулсан байна. Энэ мэт “Гэсэрийн тууж”-д мангасыг алахад мангасын амин сүлдийг түймэрдэж, бие ба сүнсийг шатаасан үйл явдал өдий төдий байдаг. “Буриад Гэсэр”¹⁵-т авай Гэсэр хаан аварга цэцэн мангасыг тайгын хөх модыг тархиар нь авчирч аварга цэцэн мангасын цавчуулсан биеийг галдаж үнсэн товрого болгож орхижээ. Бас Зас мэргэн баатар Гал нурман хааныг харваж алаад аргал түлээгээр шатааж хаясан байдаг¹⁶. Эдгээр жишээнээс үзвэл Гэсэр ба түүний баатрууд дайсан буюу мангасыг галаар түймэрдэж алах эсхүл алсаны дараа заавал галаар түлж шатаагаад ариутгаж байгаа явдал нь балар эртний үеэс уламжлагдаж ирсэн бөөгийн шашны агуулга мөн бөгөөд бас ч эртний монголчуудын заншил болно.

Нийгмийн аж ахуй ба хүний сэтгэцийн улам нэг алхам хөгжихийг дагалдан хүмүүс байгалийн хүчийг ашигтай ба аюултай хоёр зүйлд хуваан үзэх болжээ. Баларлаг үед энэхүү гал мөн хоёр зүйлийн шинжтэй байсан. Даруй эртний хүмүүс галаас зэрлэг араатан амьтантай адил зайлсан зугатаадаг. Урт хугацааны түүхийн явц ба бодит үйлдүүлгийн дунд хүн галыг аажмаар танин, түүний ашиг хорын үйлдлүүдийг ухаж мэдээд галыг ашиглаж хоол ундаа болгох буюу хүйтэнд биеэ дулаацуулах болжээ. Энэ нь хүн төрөлхтөний оршин амьдрахуйн чухал нөхцлийг бүрэлдүүлж өгсөн бөгөөд цаашид тэдгээр догшин араатнаас биеэ хамгаалах зэвсгээ болгож эхэлсэн учраас гал нь хүмүүсийн сэтгэлд хайрлалтай буюу ид шидтэй зүйл болж хүмүүст шүтэгдэн бишрэгдэх болсон байна. Хүн галыг ингэж хэрэглэсэн явдал нь хамгийн их үүдэлтийн нэг болно. Гэсэр ба түүний баатрууд хортон дайснаа дараад галаар ариутган цэвэршүүлсэн үйл явдал бий. Жишээлбэл: “Асар хүчтэн Гэсэр бодг арван гурван толгойтой арзгар хар мангасыг дарсан үлгэр”-т Гэсэр хаан арван гурван толгойтой арзгар хар мангасыг “бузар муу мангасыг бор түймэр болтол, нүгэлт муу мангасыг ногоон түймэр болтол оршигдох мангасыг улаан түймэр болтол түлж” хаяжээ. Энэ нь яг “Буриад монголын түүх”-нд тэмдэглэсэн мэт “Гал бол сүсэг бишрэлийн хэмгийн эртний элементийн нэг мөн. Галыг ариун цагааны бэлэг,

¹⁵ Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн утга зохиол судлах газрын “Гэсэр”-ийн албан гэрээс найруулсан “Буриад Гэсэр” 1-р эмхэтгэл

¹⁶ “Авай Гэсэр хөвүүн”, ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1982

сахиусны бүрэлваа, гэр бүлийн тэтгэгч гэж үздэг галыг бие ба сэтгэлийн аливаа муу муухай зүйлийг арилгах чанартай юм" гэж үздэг. "Бөө мөргөл галаар чөтгөр шулмас үлдэн хөөж, хүмүүсийн өвчин эмгэгийг эдгээж чадна гэж үздэг. Иймээс гал бол аливаа нүгэл хорыг арилгах элемент болж бөө мөргөлийн ёслолын дотор туйлын чухал үйлдэлтэй байдаг"¹⁷ гэж тодорхой заажээ.

Монголчууд аль эртнээс галыг хүндэтгэж галын сахиуснаа үргэлж тахидагыг "хар, харагчин өдөр галын сахиулсныг эрхэлж тахимой, гал голомтыг их цээрлэж шүтэж явмой. Гэрийн эзэн галын бурхан хэмээж асдаан галын ор хубун дотор хэзээ ч тасрашгүй галыг залгаж мод нүүрсийг шатааж унтраахгүй их сайн бэлэг болгож явмой. Хичнээн үеийн тахиж явсан гал хэмээж маш хүндээр эрхлэн явмой. Эр эм холбох ёсон боловч галын сахиусанд мөргөж эр эмийн хэлхээг тогтоомуй. Ийм суртал ааль нь бурханы суртал эрхийн урьд байсан ажгуу. Бурханы сургууль дэлгэрч өрх бүр шүтэж байх боловч эр эмийг холбох хэрэг галын эзэнд мөргөж эр эмийн товчоог тогтоомой. Эр эм холбох хэрэг бурхны сургаальд хaa ч үгүй буй амуй. Харин ч бэр авах, охин өгөх баяр цэнгэлийн хурумын явдал дээр бурхны ламын зүйл харшилдмүй"¹⁸ гэж галыг бурхан шашин орж ирэхээс хол өмнө эцгийн галд мөргүүлж шинэ бэрийг өөрийн овогтоо оруулан авч гал голомт онгон шүтээндээ хүндэтгэл үзүүлж байгаа хэрэг юм. Галыг Монголчууд энэ мэт хүндэтгэж хамгийн ариун цэвэр зүйлээр үзэж байдаг тул алшаа монголчууд нас барсан хүнийг оршуулаад буцаж ирэгсэдийг хоёр галын дундуур гаргаж ариутгадаг, бас бусдын өгсөн юмыг галд ариутгасны дараа сая иддэг зэрэг заншилтай. Европын жуулчин Вильям Рубрукын аялалын тэмдэглэлд Мөнх хааны хатан гаднаас авчирсан эд барааг галаар ариутгаж ордонд оруулсан гэж тэмдэглэж байна. Мангас буюу дайсан этгээдийн сүнс сүлд, хүүр ёсыг галаар шатаан түймэрддэг үйл явдал нь энэхүү заншилтай харьцаа холбоотой юм. "Гэсэрийн тууж"-д Гэсэр хааныг бяцхан хөвгүүн хувилж хүрээд чөтгөр Гүмбэ хааны хөвгүүн нь болж ордон харшид нь дураараа явах эрхийг олж уран аргаар Гүмбэ хааны баатар Гарсан зааг гал тавьж шатааж алсан үйл бий. Эдгээр нь бүр галын эд хүчийг хариулж байхаар үл барам байгалийн хүчин ба нийгмийн харгис хүчийг ялан давахын төлөө явуулсан ард түмний хатуу бэрх тэмцлүүдийг галаар дүрслэн хэлж аюул зовлонг арилгаж зол жаргалтай амьдралаа цогцлон байгуулах гэсэн хөдөлмөрчин малчдын сайн сайхан хүсэл санааг илтгэж чадсан болохоо бид тухайн нийгмийн монголын зан заншил шашин шүтлэгийн байдлыг дамаар мэдэж болно.

"Гэсэрийн тууж"-д Гэсэр өөрөө буюу гэргийнхээ зүүд зэрэглээгээр учир явдлыг урьдчилан мэдэж аливаа атаатан дайсан мангасын гэнэтийн түрэмгийллээс зайлсхийж байдаг. Зүүд гэдэг бол унтаа байгаа үест их тархины нэг хэсэг нь бүрмөсөн унтаагүйгээс шалтгаалагдсан нэгэн зүйлийн онцгой сэдэлт. Бие махбодын мэдрэлийн хөдөлгөөний ухамсаргуй ажиллагаа мөн. Бээжингийн их сургуулийн сэтгэц зүйн салбарын профессор Чин Зун Гин авгай 1986 онд Фрейдийн "Зүүдний тайлбар"-ын Хятад орчуулганд оршил бичиж өгөхдөө "зүүд бол нэгэн зүйлийн бие махбодын сэтгэцийн ажиллагаа мөн. Тэр нь унтаа байгаа үест хэсэг тархины чадвар үргэлжлэн ажилласны үр дүнд бий болдог" гэв. Яаж тайлбарласан ч хамаагүй тэр бол бодит амьдралын хүмүүсийн тархи толгойн дахь нэг зүйлийн тусгал мөн. "Гэсэрийн тууж"-д Шарай голын гурван хаан Хэнгэ шувуу болж хувилаад Гэсэрийн нутаг Рогма гуа зүүдээрээ урьдчилан мэдэж өглөө эрт Цас тэргүүтэй гучин баатар гурван зуун хошуучaa цуглувуж Рогма гуа "Би энэ шөнө муу зүүд зүүдлэв. Гэртээ минь суушгүй муу шувуу суув, үзэшгүй муу нярваа болов. Хэнгэ шувуу ирж гэр дээр

¹⁷ Ф.А.Кудряцев, Г.Н.Румянцев "Буриад монголын түүх"

¹⁸ Лувсанчойндон "Монголын зан аалийн үйлвэр" ӨМӨЗО., 1981

минь суух ба баруун дээврийг минь баруун жигүүрээрээ дарав, зүүн дээврийг минь баруун жигүүрээрээ дарав, сүүлээрээ өрхийг дарав, бүргэд өдөт сумыг олж зүүдлэв"¹⁹ гэж хэлжээ. Энэ нь хэлээнгүй бөөгийн шашны зүүд зөнг итгэж тахидаг зуршлын нэг болох юмаа. "Шарай голын гурван хааны төрийг авсан" гэх бүлэгт Гэсэр хааны зам дээр зуун наст гуйранч ламд хувилгаад хэвтэж байсан. Цагаан гэрт хааны нэгэн удган эм Чоймос гоод: "Би энэ шөнө зүүд зүүдлэж билээ. Арван зүгийн эзэн арван хорын үндсийг таслан төрсөн ачит богд мэргэн Гэсэр хааныг ирж Цагаан гэрт хаан алтан ширээн дээрээс нь шилжүүлж толгой түрүүг нь огтчин явнам гэж зүүдлэв би. Энэ наст лам биш, Гэсэр хаан хувилж ирсэн буйяа. Энэ ламын хар жанч биш, Гэсэр хааны хүхэр хар хуяг буйяа, энэ ламын хар ханз биш, Гэсэр хааны цахилгаан өнгөт далавч буйяа, энэ ламын хар малгай биш, Гэсэр хааны эрдэнэт малгай цагаан тугалга буйяа, энэ ламын барьсан гурван алд хар таяг мод биш, Гэсэр хааны бэлэг гурван алд хар шор сэлэм буйяа, одоохон би үүнийг Гэсэр гэж сананам"²⁰ гэж Гэсэрийн нууц бүхнийг нэг ч гээж орхилгүйгээр цөмийг нь оновчтой сайхан хэлсэн байна. Монголын эртний дурсгал бичиг "Монголын нууц товчоо"-нд ийнхүү зүүд зөнгийн тухай тэмдэглэл байхыг жишээ болгож дурьдавал Есүхэй баатар Тэмүжинийг есөн настай байхад бэр хэлэлцэхээр явах зам зуур Дай сэцэнтэй уулzsанд Дай сэцэн: "Би энэ шөнө зүүд зүүдлэв. Цагаан шонхор наран, саран хоёрыг атган нисч гар дээр минь буув. Энэ зүүд миний чамайг л хүүгээ удирдаж ирэхүйеэ үзсэн ажгуу. Зүүд сайн зүүдлэв"²¹ гэжээ. Эдгээр нь бүр бөөгийн шашны зүүд зөнг үнэмшин зүүдээр зөгнөл болгодгийн бодит гэрч болно. Энэ нь мөн балар эртний хүмүүс үйлдвэрлэлийн ба нийгмийн хөгжил тун дорой буурай байдал доор оршин амьдарч цаг ямагт байгалийн хөнөөл ба өөр бусдын айлган сүрдүүллэгийг амсдагаас унтаж хэвтэх үед сайн, муу, муухай, сайхан зүүдийг хэзээд зүүдэлдэг. Өдөр болсон хэрэг учир ба өөрийн санаж бодсон зүйл нь үргэлж уураг тархинд нь дахин давтагдаж зарим зүүднээсээ аиж цочиж үүний улмаас зүүдээ шүтэх үзэгдэл гардаг. Ялангуяа нас нөгчсөн өвөг дээдэс нь амьд сэргүн болгон зүүдлэх удаа арвин тохиолддог байна. Энэ бүхэн нь эртний хүмүүсийн зүүдэн шүтлэгийн үүсч бий болохын урьтал нөхцөл болсон байна. Товчилж хэлвэл монгол "Гэсэрийн тууж"-д балар эртний нийгэм буюу боол эзэмших нийгэмд өргөн тархаж хөгжлөө олж байсан бөөгийн шашны ул мөр тод товоин харагдаж байхаар барахгүй тухайн үед бөөгийн удган нар ч чухал үйлдэл зүүдэлж байсныг дам мэдээлж байна.

¹⁹ Ю.Чимэддорж харгуулан эмхэтгэсэн "Гэсэрийн тууж". ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1985

²⁰ Мөн тэнд

²¹ Манисангийн шинээр орчуулж тайлбарласан "Монголын нууц товчоо" ӨМ-ын ардын хэвлэлийн хороо., 1985